

Их хүрээнд тоглогдсон нэгэн ший жүжгийн тоглолтын тэмдэглэлийн тухай

Төмөрхүүгийн Намаа 

Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ namaa1015@gmail.com

Хураангуй: Хятадын уламжлалт жүжгийн урлаг болох ший¹ жүжгийн тоглолт нь жүжиглэлтийн арга барил, хөдөлгөөний тогтоосон дэг зэргээрээ өрнийн театрын урлагаас ялгагддаг.

1920-оод оны эцэст Нийслэл хүрээнд гэхэд хятад сонгодог ший жүжгийг Ший-Юаньз, Нан-Юаньз, мөн наймаачны Гэсэр сүмд тоглож байжээ. Эдгээрт хятад иргэд орой бүр цуглахаас гадна монголчууд ч ший жүжгийг үзэж сонирхдог болжээ.

Монгол оронд ажиллаж, амьдарч байсан хятад иргэдийн оюун санаа, соёлын хэрэгцээнд зориулан тоглолт хийж байсан эдгээр ший жүжгийн театрын талаар судлаачид тэмдэглэн үлдээсэн байна. Судлаачдын эдгээр тэмдэглэлүүдийн дотроос Нийслэл хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан “Хойд театр”-ын нэгэн тоглолтын талаар түүхч, судлаач Иван Михайлович Майский² “Хятадын театр” хэмээх сонирхолтой тэмдэглэлийг бичжээ.

Энэхүү судалгааны өгүүлэл нь И.М.Майскийн тэмдэглэлд дурдсан ший жүжгийн тоглолтын хэв шинжийг уламжлалт ший жүжгийн дэг маягийн талаас тодруулах зорилготой юм.

Түлхүүр үгс: *хятад театр, Бээжин ший, бэлгэдэл, Банзы чан*

Regarding the performance of Chinese opera carried out in Ikh Khuree

Nama Tumurkhuu 

School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ namaa1015@gmail.com

Abstract: The performance of the traditional Chinese opera, known as Beijing opera, is distinguished from Western theater arts by its acting techniques, established rules of

¹ Драмьн жүжгийн дундад эртний жижиг төрөл

² Иван Михайлович Майский (1884-1975). Зөвлөлт Холбоот Улсын дипломат, түүхч, судлаач. Түүхийн ухааны доктор, ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн гишүүн

movement, and other characteristics. Researchers have documented the Beijing opera theater, which performed to meet the intellectual and cultural needs of Chinese residents who worked and lived in Mongolia in the early 20th century. Among these, historian and researcher Ivan Mikhailovich Maisky wrote an interesting account titled “Chinese Theater” about a performance of the ‘Northern Theater,’ which operated in the capital city of the Mongolia. This research article aims to elucidate the style of the opera performance mentioned in I.M. Maisky’s account from the perspective of traditional Beijing opera practices.

Keywords: *chinese theater, Beijing opera, Symbol, Bangzi opera*

Оршил

Иван Михайлович Майский 1919-1920 онуудад Монгол орноор судалгааны аялал хийж, тухайн үеийн улс төр, нийгэм эдийн засаг, байгаль цаг уур, мал аж ахуй зэргийг судалж, түүхийн чухал эх сурвалжийг үлдээжээ. Монгол оронд ажиллаж байх үедээ нийслэл хүрээний “Хойд театр” хэмээх хятад ший жүжгийн театрт нэгэн оройн тоглолт үзсэн талаараа “Хятадын театр” тэмдэглэл бичжээ.

Тэрхүү театрт “*Бээжин шийг хятад, монгол хэлээр голчлон тоглож, хөгжим, найрал дуу, гоцлол дуу, циркийн үзүүлбэр, сэлэм жадны урлаг, кун-фу, европ, хятад илбэ оролцсон концерт, кино зэргийг үзүүлдэг*” (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 316) байжээ. Ший жүжгийн тоглолт нь жүжигчний хөдөлгөөний болон дуу хоолойн нарийн дэг маяг бүхий илэрхийллээрээ гадаад үзэгчдийн сонирхлыг татдаг байжээ.

И.М.Майский тус тэмдэглэлд ший жүжгийн тоглолтын талаар дараах зүйлсийг дурдсан байна. Үүнд:

- Ший жүжгийн театрын дотоод засал болон тайзны байдал
- Жүжигчдийн тоглолт, хувцас хэрэглэл
- Жүжгийн хөгжим
- Зургаан үзэгдлийн үйл явдлын хураангуй
- Ший жүжгийн тоглолтод үзүүлж буй үзэгчдийн хүлээн авалт зэргийг тэмдэглэн бичжээ.

Өрнийн театрын боловсролтой үзэгчийн ший жүжгийн тоглолтын тэмдэглэлд үндэслэн ХХ зууны эхэн үед Монголд тоглогдож байсан ший жүжгийн тоглолтын хэв маягийг тодруулан тодорхойлохыг зорилоо.

Судалгааны арга зүй

Судалгааг хийхдээ баримт бичгийн шинжилгээний контент анализ арга, ажиглалт, логик аргыг арга зүйн удирдлага болгон ашигласан болно.

Судалгааны үр дүн

Ший жүжгийн тайз: “Хятадын театр” тэмдэглэлд юун түрүүнд “Хойд театр”-ын дотоод засал хийгээд ший жүжгийн тайзны байдлыг дурджээ.

Ший жүжгийн тайз заслын хувьд жүжгийн үйл явдлын орчныг цомхон эд зүйлсээр төлөөлүүлэн бүрдүүлдэг. Ший жүжгийн тоглолтын явцад тухайн жүжгийн үйл явдлын орчныг хөгжим, жүжигчний тоглолт буюу дуу, биеийн үйлдлээр дамжуулан тодруулан дүрсэлдэг.

Гэхдээ тайзны тогтсон ерөнхий хэв загвар байх бөгөөд энэ нь тайзны арыг

халхалсан ерөнхий хаалт, тэрхүү хаалтын зүүн баруун хоёр талд жүжигчид тайз руу орж гарахад зориулсан хөшиг (门帘台账 men lian tai zhang) болон нэг ширээ, хоёр сандал (一桌二椅 yi zhuo er yi)-аас бүрддэг.

Тайзны энэ загварыг хөдөлгөөнгүй болон хөдөлгөөнтэй зүйлийн нэгдэл гэж тодорхойлдог. Хөдөлгөөнгүй гэдэг нь тайзны арын хаалтыг хэлэх бөгөөд жүжгийн өгүүлэмжээс үүдэн түүн дээр юуг дүрслэх нь тодорхойлогддог. Мөн энд буй хоёр хөшиг нь ший жүжгийн үйл явдлыг үзэгдэлд хуваан зааглах, цаг хугацааны үсрэлт, орон зайн хязгаарлалт бий болгоход чухал үүрэгтэй. Харин хөдөлгөөнтэй гэдэгт нэг ширээ, хоёр сандал орох бөгөөд тэдгээр нь жүжигт шууд утгаараа ширээ болон сандлыг төлөөлөхөөс гадна жүжгийн өгүүлэмжээс хамааран уул, байшин барилга, гүүр, завь зэрэг зүйлсийг төлөөлүүлэх явдал байдаг. Мөн сандал, ширээний бүрхүүл нь үйл явдлын орчноос шалтгаалж өөр өөр байна. Жишээлбэл, ордон бол шар өнгөтэй, ядуу айл бол цагаан улаан өнгө хосолсон даавуу, хөгшин хүний гэр бол ногоон өнгөтэй бүрхүүлтэй байх жишээтэй.

И.М.Майский бичсэн "... нэг талд шалнаас дээш бүтэн хагас дэлэм өндөр дунд зэргийн модон тайз байх бөгөөд тайз халхалсан том хөшиг үгүй, харин тайзны цаад хананд жүжигчидтэй ойр харилцдаг болов уу гэмээр хэдэн хүн орж гарсан, улаан хүрэн хөшигтэй хоёр жижиг хаалга харагдана" (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 316) гэсэн нь "Хойд театр"-т ший жүжгийн тайзны Мэн лиан тай жан (门帘台账 men lian tai zhang) гэх арын хөшиг ашиглаж байсныг илтгэж байна.

Ширээ, сандлыг тайзнаа хэрхэн байрлуулснаас шалтгаалж жүжгийн орчин нөхцөлийг өөр өөрөөр дүрсэлсэн болохыг илтгэх тогтсон дэгүүд байдаг ажээ. Жишээлбэл, "ширээний хоёр талд хоёр сандлыг жишүү байдлаар байршуулсан бол улсын асуудлыг зөвлөлдөж буй ордны байр байдлыг илэрхийлнэ. Нэг сандлыг ширээний хажууд байрлуулж, нөгөө сандлыг тайзны нөгөө талд тусад нь байрлуулсан бол тэр хоёр байршил нь ханаар тусгаарлагдсан болохыг илтгэнэ" (Жан Ген, Гүо Хан Чин 2010, 429). Мөн дүрүүдийн хоорондын харилцааны байдлыг илтгэхэд сандал, ширээний байршлыг ашигладаг. Сандлаар мөн хаалгыг төлөөлүүлэн дүрслэх тохиолдолд жүжигчин өөрийн урд сандлыг хөндөлсүүлэн тавьсан бол тэр хаалгаа хаасан болохыг илтгэнэ. Тэрхүү сандлыг авч хойш тавих эсвэл жишүү тавьсан бол хаалгаа нээж байгааг илэрхийлнэ.

Тус театрт ший жүжгийн тайзны уламжлалт энэхүү дэгийг хэрэглэж, тайзны хэрэглэлийг жүжгийн өгүүлэмжтэй уялдуулсан талаар И.М.Майский "охин өмнөх тайзны бүхээгээс хоёр алхмын зайд сандайлгаа ар талаар нь үзэгчид рүү харуулан тавина. Энэ нь театрын бэлгэдлээр өрөөг хааж буйн тэмдэг. Охин аажмаар зөөлөрсөөр зөөлөрсөөр сандайлгыг эргүүлэн тавина. Энэ бол өрөөний хаалга онгойсны тэмдэг" (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 500) гэж тайлбарлан бичжээ.

Ший жүжигт үзэгчдийг урих Жиан Гуан Ши (加官戏 - Jia Guan Xi) хэмээх ёслол: И.М.Майский жүжгийн тоглолтын өмнөх нэгэн үйлдлийн талаар "Тэр өмнөх тайзнаа хүрч ирэн дуу шуугүй алтан ханзны үсэгтэй жижигхэн хар өнгийн торго дэлгэн үзэгчдэд харуулна. Дараа нь хар торгоо хумьж өвөртөө хийснээ дахин өврөөсөө мөн ханз үсэгтэй улаан өнгийн жижигхэн торго гарган үзэгчдэд харуулна" хэмээн тэмдэглэжээ.

Энэ нь Жиа Гуан Ши (加官戏 - Jia Guan Xi) (Жан Ген 1994, 458) хэмээх ший жүжгийн тоглолтын эхлэлд үйлддэг жүжгийн өгүүлэмжтэй хамааралгүй тусгай ёслол юм. Нэрийн утга нь Жиа (加- Jia) Нэмэх, Гуан (官- Guan) Ноён, Ши (戏 - Xi) Жүжиг гэх үгнүүдээс бүтэх бөгөөд тухайн жүжгийг үзэхээр ирсэн хүндэт зочдыг угтах ёслол юм. “Дээд тэнгэрийн хишиг” (天官赐福 Tian Guan Ci Fu), “Сайн сайхан, амар амгалан” (吉祥如意 Ji xiang Ru yi) гэх зэрэг үгс бүхий ханз бичгийг тухайн ший жүжгийн голлон тоглогч жүжигчид (хэрэв үзэгчдийн дунд эрэгтэйчүүд олон байх тохиолдолд гол дүрийн эрэгтэй жүжигчин, харин эмэгтэйчүүд олон байх үед гол дүрийн эмэгтэй жүжигчин үйлддэг) үзэгчдийн зүгт өргөн мэндчилэх хийгээд тэдэнд ерөөл өргөн жүжгийн тоглолтыг нээдэг байна.

Жүжигчдийн тоглолт хийгээд хувцас, хэрэглэл: Ший жүжигчний өвөрмөц дуу хоолой, ер бусын биеийн хөдөлгөөн хийгээд дүрийн сэтгэлийн өнгө аясыг дохио зангааны болзолт байдлаар илэрхийлэх хэв маяг, сонирхол татам хувцас хэрэглэлийн талаар И.М.Майский хачирхан дурджээ.

Жүжигчдийн дуу хоолойны талаар “...Эхнэр нь ер бусаар чарлан, хүн гэдэг амьтанд баймааргүй дуу шуу гарган уйлж гарна” (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 499) гэхчлэн бичсэнээс үзвэл тун хачирхалтай дуу хоолой олж сонсжээ.

Ший жүжиг бол дуулалт жүжиг. Энд жүжигчний дуу хоолойгоор дүр бүтээх явдал онцгой чухал үүрэгтэй. Ший жүжигчний дуулах хэв маягийг ерөнхий хоёр арга барилд хуваан үзнэ. Эхнийх нь Шү Чин Шин (抒情性 shu qing xing) (Жан Ген, Гүо Хан Чин 2010, 304) буюу жүжигчин дүрийнхээ сэтгэл хөдлөл, байр байдлыг дуу хоолойгоороо илэрхийлэн дуулах “уянгын” хэв маяг юм. Хөгжмийн айзам хэмнэл удаавтар, дууны үг цөөн байх бөгөөд жүжигчин хоолойгоороо аялгуулан олон нугалаа гарган дуулдаг онцлогтой. Энэ үед жүжигчин цөөн үгийг дуулахдаа нэг үгийг удаанаар аялгуулан дуулах байдлаар дүрийнхээ сэтгэл хөдлөлийг илүү илэрхийлэхийг зорьдог. Дараах нь Шю Ши Шин (叙述性 xu shu xing) (Жан Ген, Гүо Хан Чин 2010, 305) буюу жүжигчин хөгжмийн айзам хурдан, огцом хэмнэлд олон үгээр хүүрнэх маягтай дуулах хэв маяг юм. Энэ үед үгсийг дуулах давтамж нь ойр бөгөөд өгүүлэмжийг хүүрнэх байдлыг гол болгож, дүрийн сэтгэл хөдлөлийн илэрхийлэл бага байдаг.

Жүжигчний үйл хөдлөлийн талаар хайрын сэдэвт жүжгийн өгүүлэмж дэх хос залуусын харилцааны хэсгийг дүрслэлийг онцгойлон “оюутан, эзний охин хоёр алчуурын хоёр талаас хэдэн минут бие биеэ учиртай шагайж харна, бас хөгжилдөн инээлдэнэ. Театрын бэлгэдлээр алчуурын хоёр талаас бие биеэ харж инээлдэх нь хайр дурлалын илэрхийлэл болдог” (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 500) хэмээн дурджээ. Хайр сэтгэлийн сэдэвт ший жүжгүүдэд эрэгтэй эмэгтэй баатруудын дунд харилцаа үүсэж буйг алчуураар дамжуулан илэрхийлэх дэгийг түгээмэл ашигладаг. Үүнийг Шу Па Чуан чин (手帕传情 shou pa chuan qing) (Ли Дан 2017) гэх бөгөөд алчуураар хосууд хайр сэтгэлээ илэрхийлэх дэг юм. Олон ший жүжигт залуу бүсгүй өөрийн алчуурыг унагах бөгөөд залуу түүнийг нь олж өгснөөр тэд харилцах нөхцөл бий болдог. Эсвэл өөрийн сэтгэлтэй хүнд алчуураа бэлэглэх нь сэтгэлээ илчилж буй илэрхийлэл юм. И.М.Майскийн бичсэн эрэгтэй, эмэгтэй баатрууд алчуурын хоёр үзүүрээс барьж зогсох нь тэдний дунд хайр сэтгэлийн харилцаа үүссэнийг илтгэнэ.

Жүжигчний хувцас, хэрэглэлийн тухайд эрэгтэй жүжигчдийн сахал, өмсгөлийн дарцаг, морь унаж буй дүрслэлд ашигладаг жижиг хэрэглэл зэргийг онцгойлон дурджээ. Ший жүжгийн гол дүрийн эрэгтэй баатрууд нь урт сахал зүүдэг. Хэрэв сахал нь гурван салаа бол энэ нь сайн талын дунд насны баатар болохыг илэрхийлнэ. Хар сахлыг ихэвчлэн өндөр хэргэм зэрэгтэй хаад, ноёдын дүр эсвэл сайн эрсийн дүрд голчлон ашигладаг. Цагаан сахал хөгшин хүний дүр болохыг илтгэхээс гадна сайхан сэтгэлтэй хүний дүрийг мөн илэрхийлнэ, бор нь нас хэвийсэн баатар эрийг илтгэнэ.

Жүжигчин сахлаараа дүрийн байр байдал, сэтгэл хөдлөлийг илэрхийлэн тоглохыг Ран Көү Гүн (髯口功 Ran Kou gong) (Жан Ген 1990, 380) гэж нэрлэдэг. Энэ нь тогтсон хөдөлгөөний дэгтэй байх бөгөөд сахлаа илэх мэт хөдөлгөөн нь санаашрах, бодлогошрох байдлыг илтгэх бол сахлаа үлээх нь эгдүүцэх, уцаарлах, үл тоомсорлох байдлыг, сахлаа хоёр тийш хүчтэй сэгсрэх хөдөлгөөнөөр уурлан бачимдах, эсвэл цочих байдлыг үзүүлнэ. Толгойгоо удаанаар сэгсэрч сахлаа хоёр тийш шидлэх нь дүрийн аргагүйдэж, мухардсан байдлыг үзүүлдэг. Хоёр гараар хоёр салаа сахлыг дээш малгайн оройн чимэглэл өөд шидлэх нь онцгой их хилэгнэж буйг үзүүлсэн дүрслэл болдог байна.

Жүжигчний дүрийн өмсгөлийн дарцгийн тухайд Жиа Зиа (扎甲 zha jia) (张庚 1999, 721) буюу Зиа (甲 jia) гэх дөрвөн дарцгийг баатрын дүрийн ший жүжигчин зүүдэг. Энэхүү дөрвөн дарцгийн өнгө нь жүжигчний нүүрний болон хувцасны өнгөтэй ижил байдаг. Зиа нь юун түрүүнд баатрын дүрийн сүр жавхлангийн илэрхийлэл болдог бөгөөд мөн тэрхүү баатар нь олон түмэн морьт цэрэгтэй болохыг илтгэдэг. Зиа дарцаг дээр Дан лун ши жү (单龙戏珠 dan long xi zhu) гэх алтан нар, луу, гарди шувуу зэргийг дүрсэлсэн байдаг.

“Гэсэр” хааны тухай ший жүжгийн өгүүлэмжид “Гэсэр хаан дайснаа дарж дуусаад, хэвтүүл офицерын гараас ногоон нахиа авч, хөлөө хаялан хол хол алхлан хөшигний цаагуур орно” гэсэн тэмдэглэлд буй “ногоо нахиа” нь Ма Бянь (马鞭 ma bian) (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 756) буюу морь унах үйлдлийг дүрслэн үзүүлэхэд ашигладаг хэрэглэл юм. Энэ нь шар, цагаан, хар, улаан, хөх, ногоон зэрэг өнгийн цацагтай байх бөгөөд жүжигчин өөрийн хувцас өмсгөлийн өнгөтэй ижилсүүлэн сонгоно. Үүний голыг модоор хийх бөгөөд жүжигчин гараасаа алдуурахаас сэргийлж үзүүр хэсэгт нь бэхэлсэн уяаг гартаа ороож барьдаг.

Ший жүжгийн хөгжим, дуу чимээ: Ший жүжигт хөгжмийн хамтлаг нь юуны түрүүнд жүжигчний дуулах ая эгшгийг тоглодог. Ингэхдээ хөгжим нь жүжгийн дүрслэлийн нэгэн илэрхийлэмж болохын тухайд дараах үүргүүдийг гүйцэтгэдэг байна.

- Дүрийг илүү тодруулах үүрэгтэй. Жүжгийн баатар тайзнаа гарч ирэхээс эхлээд түүний нийгмийн зэрэг зиндаа, зан байдлыг хөгжмөөр илэрхийлдэг. Мөн баатрын дотоод чанар, сэтгэл хөдлөлийг дэлгэрэн үзүүлэхэд хөгжмийн үүрэг оршдог.
- Жүжгийн зөрчлийг илэрхийлэх үүрэгтэй. Зөрчлийг илүү тод томруунаар дүрслэн үзүүлэхэд хөгжим чухал үүрэгтэй.
- Жүжгийн зохиолын үйл явдлын орчин, орон зай, цаг хугацааг хөгжмийн тусламжтай илэрхийлдэг. Ший жүжгийн тайзны засал нүсэр биш учир

хөгжим нь тухайн үзэгдлийг орчныг үзэгчдэд хүргэхэд чухал үүрэгтэй байдаг.

И.М.Майский “Холын аянгын нижигнэх чимээг дуурайх том ногоон тал хэнгэрэг, хоёр том зэс дэншиг, гуниглан цангинах лимбэ, дээд зэргийн шаналган авиа гаргах нарийнхан урт өвөрмөц хэлбэртэй хийл /хуучир/” (张庚 1999, 756) гэхчлэн жүжгийн үйл явдлын орчин болоод дүрийн сэтгэл хөдлөлийн илэрхийлэл хөгжмөөр хэрхэн дүрслэгдсэнийг тэмдэглэжээ.

Тэрээр хөгжмийн зэмсгүүдээс гадна “жүжигчин гар хуруундаа углан гайхалтай сайхан тачигнуулдаг инцдүүр маягийн жижигхэн хавтгай хатуу моднууд, ямар нэгэн ер бусын тод дуутай үүлдрийн модоор урласан, өөр жүжигчин түүнийг басхүү модон алхаар цохиж тоглодог нүсэр дөш зэргээс бүрдэнэ” (张庚 1999, 756) гэж ший жүжгийн нэгэн онцгой дуу чимээний хэрэглэгдэхүүний талаар бичжээ. Энэхүү модоор урласан онцгой чимээ гаргах зэмсэг нь Банзы Чан (椰子腔) ший жүжгийн хэв маягаас үүдэлтэй юм. Хятадын ший жүжгийн тоглолтыг өөр өөрөөр нэршдэгийн учир нь нэгдүгээрт, тухайн газрын нэр болон дуулах өнгө аясын онцлогоос шалтгаалдаг. Хоёрдугаарт, газрын нэр болон хөгжмийн зэмсгийг хамтатган нэрлэнэ. Гуравдугаарт, газрын нэр болон ший жүжиг тоглох онцлогоор нь ялган ангилдаг.

Банзы Чан нь Шан Ши (山西) мужид үүссэн орон нутгийн жүжгийн хэлбэр, жүжиглэх тоглолтын арга барил юм. Шан Ши муж нь Тай Хэн Шан уулын баруун талд байрладаг болохоор утгачилбал, уулын баруун гэсэн утгатай юм. Харин Банзы гэдэг нь нэгэн зүйлийн модыг нэрлэх бөгөөд түүгээр хөгжмийн зэмсэг урласнаар ший жүжгийн энэхүү хэв маяг, тоглох хэмнэлийг ийнхүү оноон нэрлэжээ.

Банзы Чан гарч ирснээс хойш ший жүжгийн хөгжилд огцом өөрчлөлт үзүүлсэн ажээ. Үүнээс өмнө уламжлалт Гүн Чан (昆腔), Го Чан (高腔) хэмээх хоёр жүжгийн тоглох арга барил голлодог байв. Эдгээр уламжлалт арга барилуудад нэг хөгжимд тогтсон хэдэн ая, аялгууг нийлүүлэн жүжгийн хөгжим бий болгодог байсан бол Банзы Чан тоглох хэлбэр бий болсноор нэг хөгжимд олон хэмнэлийн өөрчлөлт гаргаж, дүрүүдийн сэтгэл хөдлөл, дуулах арга барилд нийцүүлэн хувирдгаараа ялгаатай.

Банзы Чан нь дотроо дөрвөн төрлийн тогшуур бий. Голчлон Шань Ши Банзы гэж нэрлэдэг. Пү Жүгийн тогшуурчин (蒲州椰子), дунд замын тогшуурчин (中路椰子), хойд замын тогшуурчин (北路椰子), Шан Дан тогшуурчин (上党椰子) гэсэн жүжгийн дөрвөн төрөл зүйлтэй ба Өвөр монголын судлаачид тогшуур хэмээх нэршлийг хэрэглэдэг.

Банзы Чан ший жүжгийн төрөл нь Монгол оронд нэвтэрсэн байсан талаарх баримтууд байна. Тухайлбал, “Дундад улсын ший дууллын түүх” товхимолд “Манж Чин улсын үе буюу 1862-1937 онуудын хооронд хойд замын Банзы ший хөгжлийнхөө оргилд хүрсэн юм. Тухайн цагт энэ төрлийн ший жүжгийн 100 гаруй анги, хамтлаг Шан Ши нутагт байсан бөгөөд тэдгээр нь хамгийн холдоо Их хүрээнд очиж тоглож байсан...” (Жан Ген 1990, 89), “Чин гүрний сүүлийн үед Шан Ши худалдааны пүүсийн тоо 400 гаруйд хүрч, урт хугацаагаар арилжаа наймаа эрхэлж байгаа хятад худалдаачид 20 мянга гаруй болж, Шан Шигийн ший жүжиг нь тэдгээр худалдааны пүүсүүдтэй хамт Их хүрээнд дэлгэрсэн байна. Жишээлбэл, зүүн хүрээнд байгаа Гуан Ди сүм нь Шан Шигийн худалдаачдын барьсан сүм бөгөөд Гуан Ди сүмийн урд талд нь гоёмсог сайхан ший жүжгийн тайз байжээ. Жил

бүрийн зун дунд замын Банзы ший жүжиг тэнд тавигддаг. Олон Банзы жүжгийн жүжигчдийг Их хүрээнд байгаа Шан Ши худалдаачид урьж тоглуулдаг байв ...” (Жан Чүэн Жүэн 2013, 39). Мөн “... Шан Шигийн театрын нэгэн хүн тухайн цагтаа олонд ихэд алдаршсан Гай Шан Ший гэдэг багш шавь хоёрыг 500 ян мөнгөөр хөлслөн Их хүрээнд тоглуулан их хэмжээний ашиг олсон ...” (Жан Ген 1990, 84) гэсэн судлаачдын тэмдэглэлүүд байна. Эдгээрээс үзвэл Банзы ший жүжгийн төрөл тухайн үеийн нийслэл хүрээнд тоглогдож байсан ший жүжигт нэвтэрсэн байсан тул И.М.Майскийн жүжиг үзсэн “Хойд театр” нь Банзы ший төрлөөр тоглодог театр байсан нь тодорхой харагдаж байна.

Хөгжмийн хамтлагийн тухайд И.М.Майский “Хойд театр”-ыг зургаан хөгжмийн зэмсэгтэй гэж тэмдэглэжээ. Ший жүжгийн хөгжмийн хамтлаг (场面 chang mian) бүрэн бүрэлдэхүүн нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд хоёр хэсэгт хуваагддаг. Эхнийх нь 4 гишүүнээс бүрдэх Вэн чань (文场 wen chang) (Жан Ген 1990, 218) хөгжмийн хэсэг бөгөөд ший жүжгийн үйл явдлын ердийн нөхцөл байдлыг дүрслэн тоглодог хөгжимчдийн хэсэг юм. Үүнд Хү ху (胡呼 hu hu), Эр Сиань Гү (二股弦 er gu xian), Сан Гү Шань (三股弦 san gu xian), Си Гү Шань (四股弦 si gu xian) хөгжмийн зэмсгүүд багтдаг. Лимбэ болон Суона (唢呐 suo na) хөгжмүүдийг эдгээр чавхдаст хөгжмүүдтэй хавсарч тоглодог.

Вэн чань хөгжмийн хамтлагийн чавхдаст болон үлээвэр хөгжмүүд нь ший жүжгийн гол аялгууг тоглохоос гадна дүрүүдийн дотоод сэтгэлийн байдал, сэтгэлийн хөдлөл, уярыг илүүтэй илэрхийлдэг. Эдгээр хөгжмүүд нь сайн талын бага насны эмэгтэйн дүр (青衣 qing yi), залуу болон цовоо сэргэлэн эмэгтэй дүр (小旦 xiao dan), хөгжөөнтэй хөгшин эмэгтэй дүр (彩旦 cai dan), залуу эрэгтэйн дүр (文小生 wen xiao sheng)-үүдийг дүрслэхэд голчлон хэрэглэгддэг.

Үй чань (武场 wu chang) (Жан Ген 1990, 218) гэдэг нь голчлон дайн тулалдааны хэсгийн дүрслэлд гоцлон тоглодог хөгжимчдийн хэсэг юм. Үүнд Гү Бан (鼓板 gu ban), Ма Лө (马锣 ma luo), Рао Бо (饶钹 rao bo), Шо Ло (小锣 xiao luo), Бан Зи (梆子 bang zi) зэмсгүүд ордог. Эдгээр нь цохилтот хөгжмүүд байх бөгөөд байгалийн үзэгдлийн чимээ, амьтдын дуу, хүмүүсийн үйл хөдлөл зэргийг дүрсэлдэг. Үй чань хөгжмийн хамтлаг нь дунд насны эрэгтэйн дүр (老生 lao sheng), будагтай эрэгтэй дүр (花脸 hua lian), тулалдагч баатрын дүр (武小生 wu xiao sheng)-үүдийн илэрхийлэмжид голчлон тоглодог.

Жүжгийн үзэгдлүүдийн өгүүлэмж: И.М.Майский “Өргөөгийн театруудад орой бүр тоглох жүжгийн хөтөлбөрөөр нэг үйлдэлтэй, хоорондоо өчүүхэн ч холбоогүй хэд хэдэн жүжиг тоглодог заншилтай” (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 497) гээд зургаан үзэгдэл тус бүрийн өгүүлэмжийг товч тэмдэглэжээ. Ингэхдээ “Гэсэрийн тууж”-аас бусад зохиолын нэрийг дурдаагүй байна.

Ший жүжгийн хоёрдугаар үзэгдэлд тоглосон жүжгийн өгүүлэмжийг энд онцлон авч үзлээ. И.М.Майскийгийн тэмдэглэсэн жүжгийн агуулга нь Тан улсын үеийн ший жүжиг болох Хун Зун Ля Ма (红鬃烈马 Hong zong lie ma) (Жан Ли Шин 2015, 5) “Улаан бор хурдан морь” хэмээх ший жүжигтэй тун төстэй байна.

“Улаан бор хурдан морь” ший жүжиг нь хайр сэтгэлийн сэдэвт жүжиг юм. Энэхүү жүжиг нь Бээжин ший, Банзы ший, Чин чан, үй жү зэрэг ший жүжгийн олон хэв маягаар тоглогдож ирсэн, олны дунд ихэд алдаршсан зохиол юм. Энэхүү ший

жүжиг нь нийт 13 бүлэгтэй бөгөөд жүжгийг бүхлээр нь дөрвөн өдөр тоглодог ажээ. Жүжгийн үйл явдал Тан улсын үед өрнөх бөгөөд нэгэн тайж гурван үзэсгэлэнтэй охинтой ажээ. Тайж том хоёр охиноо хадамд гаргасан бөгөөд бага охин Ван Бао Чюн хүнтэй гэрлэлгүй өвчтэй эхээ асран гэртээ сууна. Ван Бао Чюн өвчтэй эхээ ачлалт сэтгэлээр асарч буйг улсын хатан үзээд тун ихээр үнэлж, өөрийн нөхрөө сонгох ёс үйлдэхийг зөвшөөрдөг. Ван Бао Чюн асраас бөмбөг шидэж, бөмбөгийг авсан эртэй гэрлэхээр болдог. Тэрээр өөрийн сэтгэлт залуу Шу Пин Гүйг бөмбөгийг амжиж авахыг хүсэх бөгөөд залуу хэлсэн ёсоор нь цугласан эрсийн дундаас өрсөж бөмбөгийг шүүрэн авч чаддаг. Тайж бага охиноо гуйранч эр Шу Пин Гүйтэй гэрлэх болсонд дургүйцэн хориглоно. Харин Ван Бао Чюн эцгээсээ зөрөн өөрийн сэтгэлт залуутайгаа гэрлэдэг. Тэднийг гэрлэсний хойно Шу Пин Гүй цэрэгт татагдана. Шу Пин Гүй эзэн хааны улаан бор морийг сургаж чадсанаар итгэлийг нь хүлээж, итгэмжит хүн нь болж харь оронд чухал тулаанд илгээгдэнэ. Гэвч тэрээр дайсанд олзлогдон гянданд хоригдох болов. Харь орны хаан Шу Пин Гүйн авхаалж самбаатай, эрэлхэг байдлыг үнэлэн, өөрийн охиноо түүнд өгч улсдаа амьдрахыг хүсдэг. Шу Пин Гүй ч хааны хүсэлтийг хүлээн авч, түүний охин Дай Жан Гүн Жүтэй ханилан 18 жил харь оронд амьдран суудаг. Ийнхүү 18 жилийн дараа Шу Пин Гүй өөрийн эх нутагт буцан ирдэг. Улмаар Ван Бао Чюнтэй уулзаж, 18 жилийг өөрийг нь үнэнчээр хүлээж, олон зовлон бэрхшээлийг туулан амьдарсан болохыг олж мэддэг. Шу Пин Гүй улсаасаа урвасан түшмэдийг номхотгон өөрөө хаан болдог. Хаан болмогцоо Ван Бао Чюний үнэнч сэтгэлийг үнэлэн их хатнаар өргөмжилж, Фэнь гуан (凤冠 - feng guan) (Сүн Чэн Яан, Жан Ке 2015, 217) зүүлгэж буйгаар ший жүжиг төгсдөг. Фэнь гуан буюу гардийн чимэглэлтэй толгойн засал нь их хатад болон хэргэм зэрэг өндөртэй авхай нарын толгойн чимэглэл юм. Их хатны толгойн засалд есөн гарди шувууг дүрсэлдэг бөгөөд энэ түүний асар их хүндэтгэл хүлээсэн болохыг илтгэхийн хамт сайн сайхныг бэлгэдсэн утгатай. Мөн их хатны толгойн чимэглэлийн унжлага нь шар өнгөөрөө ялгардаг. И.М.Майский үүнийг “*ахмад эхнэрийн бэлгэдэл болох титэм*” (Түмэнбаяр, Оюунчимэг 2019, 499) хэмээн тэмдэглэсэн бөгөөд түүний үзсэн тэрхүү үзэгдэл бол “Улаан бор хурдан морь” ший жүжгийн доторх “Вү жиа По” (武家坡 wu jia po) болон “Хаан өргөмжлөгдсөн нь” Да Дэн Диан (大登殿 da deng dian) бүлгүүдийн үйл явдлаас авч зохиомжилсон үзэгдэл бололтой байна.

Хэлэлцүүлэг

ОХУ-ын театр судлаач А.Борщаговский “БНМАУ-ын театр 1943” эрдэм шинжилгээний өгүүлэлдээ “Хятадын театр орчин үеийн улс төрийн хурц сэдэвтэй багавтар жүжиг, бүр тодруулбал, жижиг үзэгдлүүд тавьж үзүүлэх бөгөөд чөлөөт болохыг хүссэн Хятад орон хөрөнгөт Японы өөдөөс хийж буй тэмцлийн амин чухал асуудалд зориулсан жижиг үзэгдэл тавьж сонирхуулдаг. ... Улаанбаатарт уг театрын тавьдаг жүжгүүд орчин үеийн шинэ хурц асуудлуудыг хөнддөгөөрөө, эдгээр жижиг үзэгдлүүд нь театр зөвхөн хуучин цагийн домог түүхийг төдийгүй орчин үеийн амьд бодит байдлыг харуулж ондоогоор хэлбээс, театр нь улс төрийн индэр болж чаддаг гэдгийг иргэдэд ухуулан таниулж, сургаж байна. ... Жүжгийн агуулга нь олон зуун жилийн өмнө гарсан эртний домог байдаг. Жүжигчид нь

театрын эртний уламжлалыг хадгалж, зарим нь баг хэрэглэдэг, үзэгчид нь зохиомж тоглолтыг сайн ойлгодог бололтой” (*Түмэнбаяр, Оюунчимэг 2019*) хэмээх дүгнэлтийг хийсэн байгаа нь Ший-Юаньзын театр нь хятад иргэдийн соёл болон улс төрийн үзэл санааны төв болж байсан, театруудад тоглогдож байсан жүжгүүд нь эртний домгоос сэдэвлэсэн гэдэг агуулгатай санал нэгдэж байгаа болно. ЗХУ-ын театр судлаач эрдэмтдийн өгүүлэлд “Улаанбаатарт байсан хятад театрууд нь өөрийн орны театрын соёлыг бүрэн хадгалж чадсан тухай” олонтой дурдаж байгаа юм.

Дүгнэлт

И.М.Майскийгийн театрын тэмдэглэлээс хятад театрын өөрийн онцлог бүрэн илэрхийлэгдэнэ. Тухайн цаг үед Хятад оронд Бээжин ший жүжиг тоглохдоо, томоохон театруудад тухайн жүжгийг бүлэг бүрээр бүрэн гаргадаг байсан бол жижгэвтэр театруудад голчлон хэд хэдэн өөр жүжиг тоглодог байсан юм. Үүнийг Майский театрын урлагийн онол хандлагаар ажиглаж дурдсанаас гадна “... Эдгээр нь драмын жүжиг ч биш, инээдмийн жүжиг ч биш, харин оперетта маягийн юм. Учир нь найрал хөгжим жүжгийн дундаар байнга тоглох нь бүлгийн зарим хэсгийг онцлон харуулж байгаа нь тэр юмсанжээ” хэмээн үнэлэлт өгсөн нь Бээжин шийгийн хөгжлийн судалгаанд үнэ цэн болох дүгнэлт юм. Бээжин шийгийн дууриас ялгарах гол онцлог нь “жүжигчдийн нүүр хувиргалт, жүжгийн зохиол, томьёолсон нарийн жүжиглэлт, бэлгэдлийн чанартай хувцас хэрэглэл” болох бөгөөд Бээжин шийн орон зай, цаг хугацаа, төсөөллийн хязгааргүйг илэрхийлдэг болохыг Майскийн тэмдэглэлээс үзэж болно.

Бээжин шийгийн уламжлалт тайзны онцлогийг сонгодог урлаг өндөр хөгжсөн өрнөдийн орны хүн хэрхэн сониучирхан хүлээж авсныг анхаарах шаардлагатай. “... Хятадын театр ерөөсөө тайзны чимэглэл хэрэглэдэггүй аж. Шекспирийн үед европт чимэглэл ховор хэрэглэдэг байсан” гэсэн нь ший жүжгийн хөгжлийг европын театрын хөгжилтэй харьцуулсан дүгнэлт бөгөөд нөгөө талаас хятадуудын урлагийг үзэх үзэл болох “үзэгчид аливааг шууд хүлээн авах бус, харин мэдэрч, төсөөлөн бодох нь сайн” хэмээх санааг Бээжин ший бэлгэдэлт эд зүйлсээрээ бүрэн үзүүлдгээс гадна үндэсний “гоо зүйн” философийг илэрхийлж байсныг маш тодорхой тусган бичжээ.

“Улаан бор хурдан морь” ший жүжгийг найруулан тавихдаа, шударга, үнэн явдал бүхнийг ялан дийлдэг утга санааг илэрхийлэн гаргаж, залуусын хайр сэтгэлийн нандин утсыг хөндөн үзүүлснээр үзэгч олонд илүү таашаагдаж, анхаарлыг нь татсан бололтой. Баатарлаг үйл явдалт “Гэсэр” хааны тухай ший жүжгийн төгсөх өгүүлэмж зэргээс ший жүжгийн театрын нарийн хэрэгсэл, утга санааг тодруулан харж болохоос гадна “Гэсэр” хааны тухай жүжиг нь дэлхий дахинаа алдарт хүрсэн жүжиг болох нь илэрхийлэгдэж байна.

Монгол Улсад суурин театрын үйл ажиллагаа явуулж байсан хятад театрын тоглолтуудын талаар мэдээ баримт, тэмдэглэлүүд энэ мэт үлдсэн боловч онолын болон судалгааны арга барилын хувьд нарийвчлан судалж, уламжлалт ший жүжгийн тоглолтын дэгийн үүднээс нарийвчлан тодруулах шаардлагатай асуудлууд тулгарсаар байна.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Зориг, Б. 2018. *Монголын театрын түүх. Нэгдүгээр боть*. Улаанбаатар.

Түмэнбаяр, Ц., Оюунчимэг, Г. 2019. *Монголд ажиллаж байсан Хятад ажилчдын клуб буюу Хятадын соёлын төв*. Улаанбаатар.

Хятад хэлээр:

Жан Ген. 1994. *Дундад улсын ший жүжгийн товхимол /Өвөрмонгол боть/*. (中国戏曲志, 内蒙古卷) Хөх хот: Соёл урлагийн хэвлэлийн хороо.

Жан Ген. 1990. *Дундад улсын ший жүжгийн товхимол /Шан ши боть/*. (中国戏曲志, 山西卷) Бээжин: Соёл урлагийн хэвлэлийн хороо.

Жан Ген, Гүо Хан Чин. 2010. *Дундад улсын ший жүжгийн нийтлэг өгүүлэмж*. (中国戏曲通论 文化艺术出版社. 北京) Бээжин: Соёл урлагийн хэвлэлийн хороо.

Жан Ли Шин. 2015. ““Улаан бор хурдан морь” ший жүжгийн тархацын судалгаа.” (京剧传统剧目《红鬃烈马》的传播分析) *Магистрын судалгааны ажил*, Бээжин.

Жан Чүэн Жүэн. 2013. “*Шан Ши худалдаачин, цагаач болон ший жүжиг*.” (晋商、移民与戏曲) Ph.D дисс., Бээжин.

Ли Дан. 2017. “Алчуураар хайр сэтгэлийг дүрслэн үзүүлэх нь”, (手帕传情” — 李丹, 江都日报) *Жан дү өдрийн сонин*, 09.04.

Сүн Чэн Яан, Жан Ке. 2015. *Дундад улсын хуучны үеийн хувцасны хэв маяг*. (孙晨阳, 张珂. 《中国古代服饰辞典》) Бээжин: Ном хэвлэлийн хороо.

张庚. 1999. *Дундад улсын ший жүжгийн товхимол /Бээжин боть/*. (中国戏曲志. 北京卷) Бээжин: Соёл урлагийн хэвлэлийн хороо.

Орос хэлээр:

Боршаговский, А. 1990. “БНМАУ-ын театр.” *Үндэсний соёлын зам сэтгүүл* №1.